



**ЗАМ, ТЭЭВРИЙН  
ЯАМ**

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ  
АЛБАНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2025 он**

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ****АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2026.01.18

**Нэг. Зорилго, арга зүй**

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /АХОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан "Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам", 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам", Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэл болгосон.

**Хоёр. Танилцуулга**

АХОЗШША-ны үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 72.5%-тай үнэлэгдлээ.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

**2.1. АХОЗШША-ны 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

Нийт	Үүнээс			Хугацаа болсоогүй	Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%		
16	11	5	-	-	89.7%

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Араа хэмжээний зөвлөлт, агуулга	Хүрэх түвшин	Ирүүлсэн биелэлт	Үнэлсэн шалтгаан нөхцөл
1.	4.1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох	<b>Тухай бүр:</b> ОУИНБ болон гадаад улс орны агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах	Албаны үндсэн чиг үүргийн дагуу шинжлэн шалгах ажиллагааг явуулж, агаарын хөлгийн осол, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоож, гаргасан тайлан, дүгнэлт,	Нээлттэй мэдээллийг <a href="http://shilen.gov.mn">shilen.gov.mn</a> сайтад тайлагнаагүй.



## ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

<p>заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтоосон хугацаанд байршуулах.</p>	<p>ажиллагааны зорилго, ач холбогдлыг олон нийтэд тухай бүр танилцуулж сурталчилна.</p> <p>Мэдээллийг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулна.</p>	<p>аюулгүй байдлын зөвлөмжүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлж байна.</p> <p>Байгууллагын үйл ажиллагаанд дагаж, мөрдөж байгаа бүх хууль тогтоомж, дүрэм журам, хүний нөөцийн үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичиг, тушаал шийдвэрүүдийг цахим хуудсанд байршуулж, шинэчилж байна. Албаны даргын гаргасан нийтэд хамаатай тушаал, шийдвэрийг он, оноор нь гаргасан ба агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн бүртгэл судалгаанд суурилан осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийн, статистик судалгаа гарган, байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлдэг. Сул орон тоонд 2 ажилтан шинээр авч ажиллуулж байна. Нягтлан бодогч, гадаад харилцааны мэргэжилтэн/Цахим хуудсыг шинэ системээр дахин боловсруулж, шинэчлэн засварлах ажил хийгдэж байна, 14 мэдээлэл оруулан байршуулсан бөгөөд албаны мэдээллийн самбарт тухай бүрд байршуулан мэдээлж байна.</p>	
--	---	--	--

### 2.2. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
4	2	1	-	1	-	83,3%

### 2.3. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	0%
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
<b>Дүн</b>		<b>0%</b>



**2.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:**

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	
180	180	180	-	-	100%

**Гурав. Үнэлэлт, дүгнэлт**

**Төлөвлөлтийн байдал:**

АХОЗШША нь ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

**Хэрэгжилтийн байдал:**

1) АХОЗШША-ны үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 72.5%-тай үнэлэгдлээ.

2) 2024 он, 2025 оны эхний хагас жилд хяналт-шинжилгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараа зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албаны бүтэц, орон тоо, дүрмийг яаралтай шинэчлэн 2025 оны I сард багтаан батлуулах;
- Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэт техник технологи, инновацыг нэвтрүүлэх, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн худалдан авах зардлыг 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлэх;
- Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн тайланг улирал бүр Зам, тээврийн яаманд ирүүлэх;
- Зөрчлийг бүртгэх, мэдээлэх, цахимжуулах үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэх;

3) “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу shilen.gov.mn сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс 0%-аар үнэлэгдсэн байна.

4) 2025 онд зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд аюулгүй байдлын 4 зөвлөмж гаргасан. Нийт 18 зөвлөмжөөс 100%-тай 2, 50%-тай 3, 30%-тай 8, хэрэгжээгүй 6 зөвлөмж, хэрэгжилт 31,05 хувьтай байна.



Дөрөв. Санал, зөвлөмж

1. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг shilen.gov.mn сайтад тайлагнаж ажиллахаар шийдвэрлэсний дагуу 2026 оны эхний улиралд багтаан тус сайтад бүртгүүлж, холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах;
2. Байгууллагын эрсдлийг тодорхойлж, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах;
3. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулан хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт материалын хамт бүрэн тайлагнаж ажиллах;
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
  - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд АХОЗШЦА, яам болон ИНЕГ-ын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах.
  - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ДЭД САЙД

Г.ГАНБОЛД

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.ТУЯА

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА

Ж.ЦОЛМОН

ХЯНАСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:  
СХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Д.БАЯРМАА



**АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	16	16	89.7	20
2	Сайдын тушаалын хэрэгжилт	6	3	83.3	10
3	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	45	45	0	10
4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	180	180	100	10
<b>Нийт</b>				<b>72.5</b>	